

**“ЭРҮҮЛ ХҮНС - ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2020 ОНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

(Жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл			
1.	“Эрүүл хүнс - эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр нь Засгийн газрын 2019 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан.	Хөтөлбөрийн зорилго: Хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хэрэглээг дэмжих, хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний боловсруулах салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийн зорилго оршино.			
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	- улсын болон орон нутгийн төсөв; - гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж; - хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн эх үүсвэр; - гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт; - бусад эх үүсвэр.			
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хөтөлбөр нь 2017-2021 онд хэрэгжинэ. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ЭМЯ, МХЕГ, СХЗГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоод, ТББ.			
	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Хөтөлбөрийн хүрээнд 3 зорилт дэвшүүлсэн. Зорилт 1. хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх; Зорилт 2. хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хэрэглээг дэмжих; Зорилт 3. хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах; Зорилт 4. хүнсний боловсруулах салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх; Зорилт 5. хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх.			
5.	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)	-		
		Үүнд: Хөтөлбөр хэрэгжүүлэх зардал /сая төг/	Төсөв /2020/	Гүйцэтгэл	Хувь
		-			-
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Арга хэмжээний биелэлт: Хөтөлбөрийн 5 зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 59 үйл ажиллагаа төлөвлөгдсөн.			
	Зорилт 1	Хавсралтын 3-8 дугаар хуудас			

	Зорилт 2	Хавсралтын 8-12 дугаар хуудас					
	Зорилт 3	Хавсралтын 12-21 дүгээр хуудас					
	Зорилт 4	Хавсралтын 21-28 дугаар хуудас					
	Зорилт 5	Хавсралтын 28-32 дугаар хуудас					
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p><u>Дүгнэлт:</u> 1. Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай (Шинэчилсэн найруулга) хуульд нийцүүлэн “Хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг боловсруулж, уг үндэсний хөтөлбөрийг хүчингүй болгох нь зүйтэй. 2. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд 149.2 тэрбум төгрөг шаардлагатай гэж тооцоолсон боловч ирүүлсэн тайлангаас үзэхэд 2020 онд санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй байдал нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн гол хүчин зүйл болсон.</p> <p><u>Зөвлөмж:</u> Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай (Шинэчилсэн найруулга) хуульд нийцүүлэн 2023 он хүртэл хэрэгжих “Эрүүл хүнс-эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийг 2021 онд хүчингүй болгох асуудлыг боловсруулж, дээд шатны байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэхийг;</p>					
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	-					
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Зорилт	1	2	3	4	5
		Дундаж үнэлгээ 71.6	85.0	66.7	58.8	85.0	63.0
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ					
		-					

**ЭРҮҮЛ ХҮНС - ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН
ХАВСРАЛТ**

2020 оны жилийн эцэс

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, ҮР дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1. Хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ						
1	1.1. Хот, суурин газрын ойролцоо мах болон сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй эрхлэх, боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллахыг бодлого, арга зүйгээр дэмжих	2019 - 2023	Үйл ажиллагааны зардал		Беларусь улсын Засгийн газартай урт хугацааны хөнгөлөлттэй зээлээр сүүний чиглэлийн 3000 үнээ бүхий 5 фермийг газар тариалан бүхий бүс нутагт байгуулах хэлэлцээр хийгдэж, сонгон шалгаруулалтыг зарлаж 3 аймгийн 5 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, ферм барих газарт нь геодезийн шинжилгээ хийлгэлээ. 2020 оны 11 дүгээр сард энэ аж ахуйн нэгж нь Франц улсаас өөрийн хөрөнгөөр мөн 96 монбильярд гунжийг импортлон кластер фермээ өргөтгөхөд мэргэжил арга зүйн тулалцаа үзүүлэв. Махны, мах сүүний аж ахуйн нэгжүүдэд Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 206 иргэн аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн зааварчилгаа өгсөн байна. Мал эмнэлгийн гэрчилгээний цахим системийг энэ салбарт нэвтрүүлснээр Мал эмнэлгийн гарал үүсэл, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлүүд системд бүртгэгдсэн нь энэ салбарын хөгжилд томоохон ахиц гарсан. 2020 оны Засгийн газрын тогтоолоор Сүүний урамшуулал олгох журмыг баталж, сүүний үйлдвэрт нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуйн эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгож эхэлсэн. Төв аймагт НҮБ-ын SECIM-2 төсөлтэй хамтран “Сүү боловсруулах цехэд тавигдах шаардлага, Сүүний чанарыг хэрхэн удаан хугацаагаар хадгалах 3 удаагийн сургалт зохион байгуулж 32 иргэнийг чадавхжуулсан.Төв аймгийн 9 сумдад сүү боловсруулах цех 8, бяслагны цех 1, борлуулалтын төв 2, Эрчимжсэн аж ахуй бүхий 5 сумдад сүү төвлөрүүлэх цэг байгуулахыг бодлогоор дэмжиж 6 тн багтаамжтай 2 цэг шинээр байгуулж, сүү төвлөрүүлэх хөргөлтийн төв 32 ажиллаж байна. Дархан-Уул аймгийн Хонгор суманд 5 га газарт 236.2 сая төгрөгийн өвөлжөө, худаг ус, эмчилгээ - үржлийн ажил үйлчилгээний цэгтэй цолцолбор, Булган аймагт 150 сая төгрөгийн өртөгтэй махны чиглэлийн үхрийн цөм сүргийн аж ахуй, мал төхөөрөх 2 үйлдвэр, 120 тонн хөргөлттэй агуулах шинээр ашиглалтад орсон. Хэнтий аймагт 14 иргэнд 121.5 сая, Сэлэнгэ аймагт 25 иргэн, аж ахуйн нэгжид 352 сая, Сүхбаатар аймгийн 1 аж ахуйн нэгжид 28.0 сая, Төв аймагт 46 иргэн, аж ахуйн нэгжид 443 сая төгрөгийн зээлийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна.	100%

2	1.2. Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, буурцагт ургамлын тариалалтыг нэмэгдүүлэх	2019 - 2023	Үйл ажиллагааны зардал	Вандуй, гурвалжин будаа, шарбуурцаг, тосны ургамал, ээж будаа зэрэг эдийн засгийн хувьд үр ашигтай байх тарималуудыг сонгон тариалах, таримлын тариалах арга технологийн чиглэлээр нийтдээ 12 аж ахуйн нэгж, иргэнд биеэр, 50 орчим аж ахуйн нэгж, иргэнд утсаар зөвлөгөө зөвлөмж өгч ажилласнаар 4.7 мянган га-д гурвалжин будаа, 2.9 мянган га-д бусад буурцагт таримал тариалснаар нийтдээ 7.6 мянган га-д буурцагт таримал тариалж 3.9 мянган тонн ургац хураан авсан дүнтэй байна.	100%
3	1.3. Тосны ургамал, чихрийн манжинг таримлын сэлгээнд нэвтрүүлэх	2019 - 2023	Үйл ажиллагааны зардал	Сэлгээний таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, үрийн нөөц бүрдүүлэх тухай” асуудлаар Сайдын зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанд танилцуулга хийж, 02 тоот зөвлөмж гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаа. Энэ хаврын тариалалтад шаардлагатай байсан тосны ургамлын үр 350 тонн, Эрдэнэшишийн үр 20 тонн, вандуйны үр 30 тонн, шар будааны үр 10 тонныг тус тус импортоор нийлүүлэх ажлыг технологийн хугацаанд багтаан шуурхай зохион байгуулж, хамтран ажиллах тухай үүргийг ХААДС-д хүргүүлж хэрэгжилтийг зохион байгуулан ажилласнаар тосны ургамлын үр 150 тонныг нийлүүлэхээр Майнд тэйч ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж дамжуулан зээлдүүлэх аргаар нийлүүлэх ажлыг зохион байгуулав. Түүнчлэн импортоор тэжээлийн таримлын үр нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажилласнаар 300 тонн хошуу будаа, 50 тонн арвай, 10 тонн эрдэнэ шишийн үрийг аж ахуйн нэгжүүдэд зуучилан тариалах боломжийг бүрдүүлснээр 61.1 мянган га-д тосны, 54.7 мянган га-д тэжээлийн ургамал тус тус тариалснаар тосны ургамалын тариалалт 135.2 хувиар тус тус давж биелсэн бөгөөд ургац хураалтын дүнгээр 21.2 мянган тонн тосны ургамал, хураан авсан дүн гарлаа.	100%
4	1.4. Дотоодын загасны аж ахуйг дэмжих	2019 - 2023	Үйл ажиллагааны зардал	Монголын загас, усны амьтан үржүүлгийн салбар эдийн засгийг төрөлжүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбар юм. Энэ салбарыг ХХААХҮЯам Үндэсний хөтөлбөрүүдтэй холбон ажиллуулж аж ахуй эрхлэгчдийг дэмжсэн. Харин үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлээс чухал Төрийн зүгээс, салбарын стратегийн олон улсын байгууллагууд, ЭСЯ-даар /АНУ, БНУнгар улс, БНХАУ/ тусламжтайгаар бий болгох, хэрэглэгч, салбарын судалгааг төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн дэмжих, загасны аж ахуй эрхлэх хөдөө аж ахуйн зохистой дадалыг нэвтрүүлэх нэн чухал байгааг анхаарч ажиллаж байна. Дотоодын загасны аж ахуйг дэмжих зорилгоор Сүхбаатар сумын Сум хөгжүүлэх сангаас Сүхбаатар сумын Иргэн Э.Баярчимэгийн загас боловсруулах цехийн тоног төхөөрөмж авах төслийг дэмжин 15 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.	50%
5	1.5. Махны чиглэлийн шувууны аж ахуйг дэмжих	2019 - 2023	Үйл ажиллагааны зардал	Манайд нэг аж ахуйн буюу" Ажигана" ХХК махны чиглэлийн шувууны аж ахуйн үйл ажиллагаа эрхлэж байна. Яамны зүгээс өндөг, дэгдээхэй импортлох үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгон ажиллаж байна. Мөн мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллаж байна. 2015 онд нэг удаа хөнгөлөлттэй зээл олгож байсан. Цаашид энэ аж ахуйг дэмжих өргөжүүлэх тэжээл үйлдвэрлэхэд шаардлагатай эрдэс бодис, шувууны тоног төхөөрөмж оруулхад татварын	50%

				хөнгөлөлт болон аж ахуйгаа өргөтгөхөд зээлийн дэмжлэг үзүүлэх нөхцөл боломжийг судлаж байна. Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хороонд дэвшилтэд малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор техник, тоног төхөөрөмж бүхий сард 5000 тонн бүрэн найрлагат хорголжин болон, багсармал бүх төрлийн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай бүрэн автомат тэжээлийн үйлдвэрийг шинээр ашиглалтад оруулсан. Бүрэн автомат үйлдвэр нь дотроо нэмэлтээр премиксийн үйлдвэр, тос шахах үйлдвэр, өвс бутлах, хорголжлох үйлдвэрүүд багтсан. Монголд анх удаа премиксийн үйлдвэрийг бий болгосон байна.Хугацаа болоогүй байгаа.Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн 2019 онд 60361 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд 3 аж ахуйн нэгж, 6 иргэн хамрагдсан. Зээлийн зориулалт, үр дүнд хийсэн хяналтаар Жаргалант суманд “Жаргалантын уураг” төслөөр 1000 өндөглөгчтэй тахианы аж ахуй байгуулагдан 2020 онд160.2 мян.ш өндөг үйлдвэрлэн 49.6 сая төгрөг борлуулалт хийсэн. Мөн Жаргалант сум тахианы аж ахуйн чиглэлээр 1 иргэнд 10.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн.	
6	1.6. Өндөгний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохицуулах	2019 - 2023	0	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хугацаа болоогүй.	100%
7	1.7. Байгаль, цаг уурын онцлогоос шалтгаалан дотоодын үйлдвэрлэл хязгаарлагдмал цагаан будаа, элсэн чихэр зэрэг бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангахад гадаад худалдааны түнш орнуудтай яриа хэлэлцээ хийх	2019 - 2023	0	БНСУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах судалгааны шатанд тус улсаас цагаан будаа импортлох тарифыг хөнгөвчлөх санал боловсруулж байна. Цагаан будаа нь хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нэг бөгөөд хангамжийн хувьд импортоос 100 хувийн хамааралтай байдаг бөгөөд тусгайлан бүрдүүлсэн нөөц байдаггүй онцлогтой. Монгол Улс 2019 онд 43.7 мянган тн цагаан будааг 17 улсаас импортолсон бөгөөд импортын цагаан будааны 45.5 хувийг Вьетнам улсаас, 44.8 хувийг Хятад улсаас тус тус бүрдүүлжээ. Манай улсын 6 аж ахуйн нэгж Вьетнамаас 10500 тн цагаан будаа импортлох худалдааны гэрээг байгуулсан. Гэвч БНСУ-ын Засгийн газраас цагаан будааны экспортоо түр түдгэлзүүлсэнтэй холбогдуулан манай аж ахуйн нэгжүүдийн худалдааг энэ хоригт хамруулахгүй байх тухай ноот бичгийг холбогдох материалын хамт хүргүүлсэн. Манай талаас авч хэрэгжүүлсэн шат дараатай арга хэмжээний үр дүнд Вьетнам улс Монгол Улсын импортлох цагаан будаанд квот тогтоохгүй талаар тус улсын Элчин сайд 2020 оны 5 дугаар сард мэдэгдсэн. Цагаан будааны импорт хэвийн үргэлжилж байна.	100%
8	1.8. Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих тарифын болон тарифын	2019 - 2023	0	Стратегийн хүнсний дотоодын хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарал, үнийн хэт хэлбэлзлээс сэргийлэх, гадаад худалдааны уламжлалт болон шинэ түнш орны зорилтот зах зээлд стратегийн хүнсийг экспортлохыг дэмжих, стратегийн хүнсийг экспорлох, импортлох зөвшөөрөл олгох үйл явцыг	100%

	бус зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх			шуурхай болгох зорилгоор Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журмыг шинэчлэн боловсруулж, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор батлуулсан. Журмын хэрэгжилтийг тодотгох, нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан бөгөөд Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. ДХБ-ын Хамгаалалтын арга хэмжээний хэлэлцээрийг хэрэгжүүлэх журмын төслийг ГХЯ-тай хамтран 2020 оны 3-5 дугаар сард боловсруулсан. Гэвч Хууль зүй, дотоод хэргийн яамнаас энэ журмыг хууль давсан зохицуулалттай гэдэг үндэслэлээр дэмжих боломжгүйгээ мэдэгдсэн. Энэ журмыг баталж, хэрэгжүүлснээр дотоодын зах зээлийг тарифын бус зохицуулалтын арга хэрэгслээр хамгаалах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих нөхцөл, боломж бүрдэнэ. Ковид-19 халдвар цар тахал зөөвөрлөгдөж бүртгэгдсэнтэй холбогдуулан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг 2020 оны 4 дүгээр сард батлуулж, импортын хамааралтай төрөл бүрийн будаа /цагаан будаа, шар будаа, гурвалжин будаа болон бусад/, элсэн чихэр, ургамлын тосны гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2020 оны 2 дугаар сарын 19-нээс 6 дугаар сарын 30-ны дуустал хугацаанд чөлөөлүүлсэн. Ковид-19 халдвар цар тахал дотоодод бүртгэгдсэнтэй холбогдуулан мөн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг 2020 оны 12 дугаар сард батлуулж, төрөл бүрийн будаа, ургамлын тос, хүнсний болон үрийн улаанбуудайн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2020 оны 12 дугаар сарын 01-нээс 2021 оны 7 дугаар сарын 01-нийг хүртэл хугацаанд чөлөөлүүлсэн.	
9	1.9. Хөдөө аж ахуйн түүхий эд бэлтгэл, тээвэр-логистикийн сүлжээ байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих	2019 - 2023	0	Улаанбаатар хотод мал төхөөрөх үйлдвэр, махны худалдаа логистикийн цогцолбор байгуулах "МБҮ трейд" ХХК-ийг бодлогоор дэмжиж, тус цогцолборын бүтээн байгуулалтад шаардагдах түүхий эд, материалын гаалийн болон НӨАТ-ыг хойшлуулах Засгийн газрын тогтоолыг 2019 онд батлуулсан. Энэ бодлогын хүрээнд хэрэгжилтийг зохион байгуулахаар Сангийн яам, ХХААХҮЯ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон "МБҮ трейд" ХХК хооронд байгуулах дөрвөлсөн гэрээний төслийг бэлтгэн баталж, Сангийн яаманд хүргүүлсэн. Тус цогцолбор 2020 оны 4 дүгээр улиралд ашиглалтад орох төлөвлөгөөтэй байсан боловч Ковид-19 халдварт цар тахлын нөхцөл байдлын улмаас хойшлогдсон.	50%
10	1.10. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх арга хэмжээг орон нутагт хувийн хэвшлийн оролцоотой зохион байгуулах	2019 - 2023	0	Дотоодын махны хангамжийг тогтворжуулах зорилгын хүрээнд Нийслэлийн хүн амын 2020 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан Засгийн газрын 2019 оны 285, 329 дүгээр тогтоолын дагуу арилжааны банкны эх үүсвэрээр болон экспортлосон махны 10 хувьтай тэнцэх тоо хэмжээний махыг нийлүүлэх бодлогын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн, нийт 12.6 мянган тн махыг дотоодын зах зээлд нийлүүлэхээр бэлтгэсэн. Хувийн хэвшлийн оролцоотой бэлтгэж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах ажлыг 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс 07 дугаар сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж,	100%

					Нийслэлийн 9 дүүргийн 169 хорооны хүнсний 413 дэлгүүрээр дамжуулан хонины ястай мах 6700 төг/кг, үхрийн ястай мах 7700 төг/кг, ямааны мах 6200 төг/кг үнээр худалдаалсан.	
2. Хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хэрэглээг дэмжих зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ						
11	2.1. Хүнсний хэрэглээ, шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хооллох дадлыг төлөвшүүлэх чиглэлээр “Ээжийн сонголт – Эрүүл хүнс” болон “Өглөөний цай” хөдөлгөөн өрнүүлэх	2019 - 2023	0		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас “Монголын эмэгтэйчүүдийн хөгжлийн манлайлал” ТББ-тай хамтран “Өглөөний цай” болон “Ээжийн сонголт – Эрүүл хүнс” хөдөлгөөний хэлэлцүүлгийг 2020 оны 1 дүгээр сарын 10-нд Төрийн ордонд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан, Дэд сайд Ж.Сауле, ЭМ-ийн сайд Д.Сарангэрэл тэргүүтэй холбогдох төрийн байгууллага болон цэцэрлэг, дунд сургуулиудын удирдлага, багш, эцэг эх, мэргэжлийн тогооч нарын төлөөлөл оролцлоо. Хэлэлцүүлэгт “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр – Хэрэглэгчийн боловсрол”, “Өглөөний цай эрүүл мэндэд нөлөөлөх нь”, “Хүн амын хүнсний хэрэглээнд шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэхийн ач холбогдол”, “Гэр бүлийн хүнсний хэрэглээний сонголтыг ээжүүд гүйцэтгэдэг” сэдэвт илтгэлүүд тавигдаж, асуулт, хариулт, санал хүсэлт, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Хэлэлцүүлгээс олон нийтэд хандсан уриалга гаргасан. "Өглөөний цай" болон "Ээжийн сонголт - Эрүүл хүнс" хөдөлгөөнийг өрнүүлж, сурталчилгааны шторкыг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын суурин төлөөлөгчийн газартай хамтран гүйцэтгүүлсэн. Дэлхийн хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын өдрийг угтан зохион байгуулсан 2020 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хэвлэлийн бага хурлын үеэр сурталчилгааны шторкыг сэтгүүлчдэд танилцуулсан. Хөдөлгөөний шторкыг Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран ТВ5, UBS, ETV, MNC, VTV телевизүүдээр өдөрт 3 удаагийн давтамжтайгаар өглөө, өдөр, орой нэвтрүүлэн олон нийтэд сурталчлав.	100%
12	2.2. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол олгох сургалтын байгууллагын хичээлийн хөтөлбөрт “Хоол, хүнсний зөв сонголт, зохистой хэрэглээ” агуулгыг тусгаж, хэрэгжүүлэх	2019 - 2023	0		Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хугацаа болоогүй.	30%
13	2.3. Хүнсний бүтээгдэхүүний шошго, хоолны цэсэнд тухайн бүтээгдэхүүний шим	2019 - 2023	0		Хоолны цэсэнд хоолны шим тэжээлийн үзүүлэлтийг тусгах заалтыг "Хоолны газарт тавих шаардлага 4946:2019" стандартын 11.2-д "Хоолны цэсэн дээр хоолны шим тэжээл, давсны болон сахарын агууламжийг тодорхойлж бичсэн байна. Хоолны шим тэжээлийн, илчлэг, давсны агууламжийг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж, баталгаажуулсан байна. Дотоод хяналтын хүрээнд тооцооны аргаар нягталж бүртгэл хөтлөнө" гэсэн заалтыг тусган, СХЗГ-ын	70%

	тэжээлийн үзүүлэлтийг тусгаж хэвшүүлэх				даргын 2019 оны 7-р сарын тушаалаар батлуулсан. Уг стандартыг сурталчлах сургалтыг НЗАА-ны ХХҮҮХ-тэй хамтран 2020 оны 2-р сард нийслэлийн 6 дүүргийн 600 гаруй хоолны газрын менежер, ахлах тогооч нарыг оролцуулан зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласны дагуу НЗАА-ны хүнс, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсээс хийсэн аттестатчлалын дүнгээр нийслэл хотод рестораны үйл ажиллагаа явуулж буй 100-аад хоолны газар хоолны цэсэн дээр тусгасан.	
14	2.4. Хүнсний бодит хэрэглээний судалгааг улирлаар бүсчлэн хийж, зөвлөмж боловсруулах	2019 - 2023	0		Арга хэмжээний санхүүжилт 2020 оны улсын төсөвт тусгагдаагүй.	100%
15	2.5. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний найрлагын хүснэгтийг 3 жил тутамд шинэчлэх	2019 - 2023	0		Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хугацаа болоогүй.	100%
16	2.6. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоолны жор, орцын зохистой харьцааг хүн амын физиологийн зөвлөмж хэмжээтэй уялдуулан тогтоож, мөрдөх	2019 - 2023	0		УИХ-аас Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг 2019 онд баталсан. Энэ хуульд сургуулийн хүүхдийн хоол хүнснээс авбал зохих шим тэжээл, илчлэгийн хэмжээг тодорхойлох, мөн тусгай хоолны дэглэмтэй хүүхдэд зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоолны жишиг цэс, зөвлөмж гаргах чиг үүргийг Эрүүл мэндийн яам хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ ажлын хүрээнд тус яамтай хамтран ажиллаж байна. Орон нутагт ЕБС-ийн үдийн хоолны хангамжийн бие даасан байдлыг бэхжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний схемийг бэлтгэж БСШУСЯ-нд 2020 оны 5 дугаар сард хүргүүлэв.	30%
17	2.7. Эрүүл мэндийг дэмжих үйлчлэлтэй хүнсний дотоодын үйлдвэрлэлийг гадаад улс, олон улсын байгууллагын хөтөлбөр, төсөлд хамруулах замаар дэмжих	2019 - 2023	0		Эрүүл мэндийг дэмжих үйлчлэлтэй хүнсний үйлдвэр байгуулах ТЭЗҮ, төслийн танилцуулгыг англи хэл дээр бэлтгэж “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх уулзалтын үеэр гадаад улс, олон улсын байгууллагуудад санхүүжилт татах зорилгоор танилцуулав. 2.Эрүүл мэндийг дэмжих үйлчлэлтэй хүнс буюу баяжуулсан хүнсний үйлдвэрлэлийг дэмжих, баяжуулсан хүнсний дотоодын үйлдвэрийг дэмжих зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Баяжуулсан хүнсний тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн яам болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран дараах стандартуудыг боловсруулж, батлуулсан. Үүнд: 1. "Баяжуулсан буудайн гурил техникийн ерөнхий шаардлага. MNS 6812-2019", 2. "Буудайн гурилыг баяжуулагч бэлдмэл. Техникийн ерөнхий шаардлага. MNS 6811-2019", 3. "Хүнсний зориулалтын иоджуулсан давс. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5046-2019" Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт” төслийн шугамаар нийт 945.3 сая төгрөгийн үнэ бүхий чацарганы	70%

				үрийн тосыг орчин үеийн өндөр технологийн нүүрсхүчлийн хийгээр хандлах аргаар ялгаж авах тоног төхөөрөмжийг ШУТИС-д суурилуулсан. Энэ арга хэмжээний үр дүнд олон улсын стандартад нийцсэн чацарганы үрийн тосыг гаргаж авах, судалгаа шинжилгээнд ашиглах, улмаар чацарганы бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэв.	
18	2.8. Сахар чихрийн зүйл , транс тос, давсны агууламж өндөртэй бүтээгдэхүүний нийлүүлэлт, хэрэглээг бууруулах арга хэмжээ авах	2019 - 2023	0	“Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” аяныг 2019 онд улсын хэмжээнд зохион байгуулж, тус аянд хүнсний чиглэлийн 260 гаруй байгууллагыг хамруулав. Аянд хамрагдсан хүнс үйлдвэрлэгчид, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгчид хоол, хүнсний бүтээгдэхүүнийхээ давсны агууламжийг 60 хүртэл хувиар бууруулж, нийгмийн хариуцлагын хүрээнд сургалт, сурталчилгаа зохион байгуулсан. Цаашид саахар, чихрийн зүйл, транс тосны агууламж өндөртэй бүтээгдэхүүний импорт, худалдаа, нийлүүлэлтийг зохицуулах арга хэмжээний саналыг боловсруулж байна.	50%
19	2.9. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын тогтвортой хөгжлийг дэмжих “Монгол үндэстний хоол” төсөл боловсруулж хэрэгжүүлэх	2019 - 2023	0	Монгол үндэстний хоол” техник туслалцааны төслийн баримт бичгийг боловсруулж, “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх уулзалтын үеэр гадаад улс, олон улсын байгууллагуудад танилцуулав. /Англи хэлэнд орчуулсан/ Тус төслийг хэрэгжүүлэх саналыг гадаад улс, олон улсын байгууллагуудад тавих асуудлаар ГХАХ-т 2020 оны 3 дугаар сард хүргүүлэв. Мөн төслийг ЕХ-ны шугамаар хэрэгжүүлэх саналыг 2020 оны 12 дугаар сард мөн хүргүүлсэн.	50%
3. Хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ					
20	3.1. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн цахим бүртгэлийг боловсронгуй болгох	2019 - 2023	0	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэх, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх техник туслалцааны төслийн баримт бичгийг боловсруулж, “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх уулзалтын үеэр гадаад улс, олон улсын байгууллагуудад танилцуулав. /Англи хэлэнд орчуулсан/ Тус төслийг хэрэгжүүлэх саналыг гадаад улс, олон улсын байгууллагуудад тавих асуудлаар ГХАХ-т 2020 оны 3 дугаар сард хүргүүлэв. Органик хүнсний тухай хууль тогтоомжийн хүрээнд органик хүнс үйлдвэрлэл, баталгаажуулалтын цахим бүртгэлийн санг үүсгэн байгуулж, ашиглаж байна. Хүнсний нэмэлт, баяжуулагч бэлдмэл, цэвэр өсгөвөрийн хөрөнгө импортлогч аж ахуйн нэгжийн хүсэлтийг үндэслэн холбогдох журмын дагуу бүртгэж байна. 2020 онд 142 хүнсний нэмэлт, 19 өсгөвөрийн хөрөнгө, 3 баяжуулагчийг бүртгэсэн байна. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэх, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн нэгдсэн цахим сангийн ажлын даалгаврыг 2020 оны 2 дугаар улиралд боловсруулсан. Цахим санг бий болгох ажлыг гүйцэтгүүлэх төсвийн саналыг боловсруулж СХОГ-т хүргүүлсэн. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журмыг Эрүүл мэнд,	50%

				Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдыг хамтарсан тушаалаар батлаад байна.	
21	3.2. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах, ул мөрийг мөрдөн тогтоох мэдээллийн цахим сан бий болгох	2019 - 2023	0	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэх, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх техник туслалцааны төслийн баримт бичгийг боловсруулж, “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх уулзалтын үеэр гадаад улс, олон улсын байгууллагуудад танилцуулав. /Англи хэлэнд орчуулсан/ МЭЕГ-аас Мал, махны гарал үүслийг тодорхойлохдоо мал эмнэлгийн баталгаажуулалтын системийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Тус системд малчны мэдээлэл, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийн дугаар, маршрут, тээвэрлэх хугацаа, хяналтын цэг, эрүүл мэндийн баталгаажуулалт, махны ямар үйлдвэрт хүргэгдэх зэрэг мэдээллийг баг, сумын малын эмч оруулж, хэвлэгч төхөөрөмжийг ашиглан, мал эмнэлгийн гэрчилгээг шууд цахимаар хэвлэдэг болсон. Үйлдвэрт нийлүүлсэн малыг хүлээн авсны дараа, бар код болгон хувиргаж үйлдвэрээс гарч буй махны баглаа боодолд бар кодыг хэвлэн худалдаанд нийлүүлнэ. Хэрэглэгчид гар утасны тусгайлан гаргасан цахим аппликейшнийг ашиглан бар кодыг уншуулж махны гарал үүсэл болон холбогдох мэдээллийг авах боломжтой юм. Тус системийг улсын хэмжээнд нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Төв аймгийн Борнуур, Сүмбэр сумын сүүний чиглэлийн аж ахуй эрхлэгчдээс сүү худалдаж авах “Сүүний чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтын лавлагаа мэдээллийн цахим систем”-ыг туршилтийн журмаар Швейцарийн хөгжлийн агентлагийн төслийн хүрээнд ХААҮШУОНТөв, “Витафит Милк” ХХК, “Дижитал Медик” ХХК-иудтай хамтран амжилттай нэвтрүүлсэн.	70%
22	3.3. Ургамал хамгааллын бодис, бордоо, малын эмийн чанар, аюулгүй байдал, хэрэглээнд тавих хяналтыг сайжруулах	2019 - 2023	Үйл ажиллагааны зардал	Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчлэсэн найруулгын төслийг боловсруулж байна. Уг шинэчилсэн найруулгаар зөвхөн ургамал хамгааллын төдийгүй ургамлын эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн нэмэлт өөрчлөлтийг Ургамал хамгааллын олон улсын конвенцийн агуулгатай нийцүүлэн боловсруулж байна. Үүнээс гадна бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэхдээ баримтлах "Мэрэгчидтэй тэмцэх арга" MNS6866:2020, "Хөнөөлт царцаатай тэмцэх химийн аргаар тэмцэх ерөнхий шаардлага" MNS6766:2019 улсын стандартуудыг батлуулан мөрдөж эхлээд байна. Ургамал хамгааллын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журмыг батлуулсан.Эдгээр техникийн баримт бичгүүд батлагдсан хэрэгжиж эхэлснээр бэлчээрийн ургамал хамгаалалд ашиглах ургамал хамгааллын бодисын зарцуулалт, ашиглалтад хяналт тавьж ажиллах эрхзүйн орчин сайжирсан.Ургамал хамгааллын бодис бордооны аюулгүй байдлын хүрээнд жил бүр “Пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг турших, ашиглах журам”-ын дагуу Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал газар тариалангийн хүрээлэн, МЭЕГ-аас 2020 онд ашиглах химийн гаралтай ургамал хамгааллын бодис, химийн бордоо, мал эмнэлгийн зориулалттай ариутгал халдваргүйтгэлийн бодисын жагсаалтын	90%

				төслийг нэгтгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/125, А-69, А/143 дугаар тушаалаар 2020 онд ашиглаж болох пестицид, химийн бордоо, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалтыг батлуулсан. Жагсаалтад орсон бодисын чанар аюулгүй байдлыг хянах зорилгоор Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн болон Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораториас жил бүр тайлан мэдээг хүлээн авч байна. Эдгээр байгууллагуудын лабораториудад 2018-2020 ондуудад нийт 1591 пестицидийн үлдэгдлийг тодорхойлох шинжилгээг хийхэд эерэг үзүүлэлттэй дүн гараагүй байна.	
23	3.4. Хүнсний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн /GAP/ зохистой дадалыг нэвтрүүлж баталгаажуулах	2019 - 2023	Үйл ажиллагааны зардал	Швейцарын хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй Монгол ногоо төслийн багтай хамтран "Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд ХААЗД-ын хялбаршуулсан заавар нэвтрүүлэх, Ургамал хамгааллын цогц арга хэмжээ" сэдэвт төрийн албан хаагчдыг чадавхижуулах цахим сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтын хөтөлбөрт хөрсний үржил шимийг сайжруулах, элэгдэл эвдрэлээс хамгаалах, эрдэс ба органик бордоо бэлтгэх, зохистой хэрэглээний талаар аймаг орон нутгийн хөдөө аж ахуй, газар тариалан хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан мэргэжлийн байгууллага, эрдэмтэн багш нараар илтгэл тавиулах, хичээл заах үйл ажиллагааг зохион байгуулсан. Одоогийн байдлаар ХААЗД-ыг нэвтрүүлсэнийг баталгаажуулах үйл ажиллагаа эрхлэх итгэмжлэлийг 1 аж ахуйн нэгж шаардлага ханган авсан ба тус аж ахуйн нэгж нь тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 19 иргэн, аж ахуйн нэгжүүд өөрсдийн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал хэрэгжүүлсэнийг баталгаажуулан ХААЗД-ын гэрчилгээг олгоод байна.	50%
24	3.5. Хүнсний боловсруулах салбарт Үйлдвэрлэлийн /GMP/ зохистой дадалыг нэвтрүүлж, баталгаажуулах	2019 - 2023	0	Хүнсний боловсруулах салбарт Үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/ хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг боловсруулсан, төслийн хэлэлцүүлгийг дотоодын хүнс үйлдвэрлэгчид, мэргэжлийн холбоодыг оролцуулан 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж гарсан саналыг нэгтгэсэн. Үйлдвэрлэлийн зохистой дадал нь Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо олон улсын стандарт нэвтрүүлэхийн урьдач нөхцөл болох бөгөөд манай улсад тус олон улсын стандартыг нэвтрүүлсэн 11 үйлдвэр байна. Зохистой дадалыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг ХХААХҮ-ийн Сайдын зөвлөлийн 2020 оны 2 дугаар сард хэлэлцүүлж, дэмжигдсэн. Мөн тус зааврын төслийг хамтран батлах ЭМЯ-наас дэмжсэн албан тоотыг ирүүлсэн. Зааврын төсөлд ҮАБЗ-ийн ажлын албанаас ирүүлсэн саналыг тусгаж эцэслэн боловсруулсан. ХХААХҮ-ийн сайдын болон ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахад бэлэн болгов.	70%
25	3.6. Улс, орон нутгийн түвшний хүнсний аюулгүй байдлын	2019 - 2023	0	Монгол Улсын үндэсний итгэмжлэлийн байгууллага “Олон улсын итгэмжлэлийн форум” байгууллагад (IAF)-д нэгдэн орсноор манай бизнес эрхлэгчид дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн лого бүхий гэрчилгээ хэрэглэх, үндэсний баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн үр	30%

	лабораториудын чадавхийг сайжруулах, итгэмжлэлийн хүрээг өргөтгөх, лабораториудад зохистой дадал нэвтрүүлэх, олон улсын итгэмжлэлд хамруулах			дүнг бүтээгдэхүүн, менежментийн тогтолцоо (чанар, байгаль орчин, хүнсний аюулгүй байдал)-ны чиглэлээр хүлээн зөвшөөрөгдсөн. Улсын хэмжээнд хүнсний сорилтын чиглэлээр итгэмжлэгдсэн 91 лаборатори ажиллаж байна. Лабораториудыг харьяаллын байдлаар авч үзвэл: - ХХААХҮЯ-ны харьяа мал эмнэлгийн 20 /төрийн/; - МХЕГ-ын харьяа 28 /төрийн/; - Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын 6 /төрийн 4, хувийн 2/; - Хүнсний үйлдвэрийн дотоод хяналтын 32 /хувийн/; - Хүнсний захын дэргэдэх 4 лаборатори /хувийн/. Монгол Улсын лабораториудын зөвлөлдөх уулзалтыг 2020 онд зохион байгуулахаар төлөвлөж байна. Азийн хөгжлийн банкны шугамаар хэрэгжүүлж байгаа “SPS-ийн арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд Замын-Үүд, Алтанбулаг боомт дахь мэргэжлийн хяналтын лабораторийг бэхжүүлэх ажил хийгдэж байна. Улсын хэмжээнд итгэмжлэгдсэн хүнсний сорилтын лабораториудын сүлжээг байгуулах, харилцан мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх зорилготой зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулахаар бэлтгэж байсан боловч Ковид-19 халдварт цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан цуцалсан. Шинжилгээний арга аргачлалын дараах стандартыг 2020 онд баталсан байна. Үүнд: Хоолны илчлэгийг тодорхойлох шинжилгээ	
26	3.7. Хүнсний үйлдвэр, зах, худалдааны төвүүдэд дотоод хяналтын лаборатори байгуулах, бэхжүүлэхэд нь санхүүгийн болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх	2019 - 2023	0	Хүнсний үйлдвэр, зах, худалдааны төвүүдийн дотоод хяналтын лаборатори байгуулах, бэхжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний санхүүжилт 2020 оны улсын төсөвт тусгагдаагүй.	100%
27	3.8. Хүнсний салбарын техникийн зохицуулалт, үндэсний стандартыг шинэчлэх, шинээр боловсруулах, олон улс, бүс нутгийн стандартыг нутагшуулах	2019 - 2023	0	Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлийн тухай хуульд тогтоомжид нийцүүлэн Махны үйлдвэрлэл, худалдааны мөрдөх техникийн зохицуулалтын төслийг 2020 онд шинэчлэн боловсруулсан. Тус зохицуулалтын төслийг 2021 оны эхний улиралд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. 2020 онд дараах стандартууд батлагдсан байна. Үүнд: 1. Хүнсний арвай. Техникийн ерөнхий шаардлага. 2. Хагас боловсруулсан гурилын бэлдэц. Техникийн ерөнхий шаардлага. 3. Төмс, хүнсний ногоог хадгалах арга. 4. Хоолны илчлэгийг тодорхойлох шинжилгээний арга. 5. Тамхины түүхий эд. Ерөнхий шаардлага. 6. Дүнсэн тамхи. Ерөнхий шаардлага. 7. Арвайн болсон гурил. Техникийн ерөнхий шаардлага. 8. Сүү, сүүн бүтээгдэхүүн. Сахар тодорхойлох арга. 9. Мах, махан бүтээгдэхүүн. Нитрит тодорхойлох арга. 10. Хүнсний бүтээгдэхүүн. Ханаагүй тосны хүчлийн транс изомерийн агууламж тодорхойлох нил улаан туяаны спектрометрийн арга. 11. Хүнс ба малын тэжээлийн микробиологи. Микробиологийн шинжилгээний заавар, ерөнхий шаардлага. 12. Хүнс тэй хүрэлцэхэд аюулгүй тэмдэг 13. Хүнсний	70%

				аюулгүй байдлын угтвар нөхцлийг хангах хөтөлбөр. 4-р хэсэг. Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл. 14. Хатаамал сүү, сүүн бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага.	
28	3.9. Олон улсын Хүнсний хууль эрх зүйн хороотой хамтран ажиллах Кодексийн үндэсний зөвлөлийг чадавхжуулах, тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх	2019 - 2023	0	Монгол Улсад Кодексийн үндэсний чадавхийг бэхжүүлэх техник туслалцааны төслийн саналыг бэлтгэсэн. Төслийг НҮБ-ын ХХААБ болон ДЭМБ-ын хамтарсан Хүнсний эрх зүйн хорооны Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлнэ. Кодексийн үндэсний зөвлөлийг бэхжүүлэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор www.codexmongolia.com хуудсыг бий болгох ажлын даалгаврыг 2020 оны 4 дүгээр сард боловсруулсан. Энэ ажлыг НҮБ-ын ХХААБ болон ДЭМБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа Хүнсний хяналтын тогтолцоог сайжруулах төслийн шугамаар 2021 оны эхний улиралд гүйцэтгүүлнэ. АХБ-ны шугамаар хэрэгжүүлж байгаа Төв Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хүнсний аюулгүй байдлын стандартчиллыг сайжруулах төслийн хүрээнд кодексийн чиглэлээр олон улсын эксперт урьж 2020 оны 6 дугаар сард сургалт хийхээр төлөвлөж байсан боловч Ковид-19 халдварт цар тахлын улмаас 9, 10, 11 дүгээр сар хүртэл хойшилж, сүүлд цуцалсан.	30%
29	3.10. Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэл, импортын кластер байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих	2019 - 2023	0	ХХААХҮЯ-наас НҮБ-ын ХХААБ болон ДЭМБ-тай хамтран “Хүнсний хяналтын тогтолцоог сайжруулах” техник туслалцааны төслийг хэрэгжүүлэхээр тохиролцож, төслийн нээлтийн семинарыг 2019 оны 4 дүгээр сарын 30-нд зохион байгуулсан. Төслийн хүрээнд пестицидийн үлдэгдлийг хянах төлөвлөгөөний төслийг боловсруулж, цахим хэлэлцүүлгийг 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулсан. Ковид-19 халдварт цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан тус төслийн хэрэгжих хугацааг 2021 оны 9 дүгээр сар хүртэл сунгасан. Төслийн хүрээнд импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хорио цээр, чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулах бодлогын арга хэмжээний санал боловсруулна. Азийн хөгжлийн банкны шугамаар хэрэгжүүлж байгаа “SPS-ийн арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд Замын – Үүд, Сүхбаатар, Алтанбулаг хилийн боомтуудын хяналт, шалгалтын цогцолборыг барьж байгуулах зураг төслийг 2019 онд боловсруулж батлуулсан. Өргөтгөлийн ажлыг 2020 онд эхлүүлсэн байна.	30%
30	3.11. Импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хорио цээр, чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулах	2019 - 2023	0	ХХААХҮЯ-наас НҮБ-ын ХХААБ болон ДЭМБ-тай хамтран “Хүнсний хяналтын тогтолцоог сайжруулах” техник туслалцааны төслийг хэрэгжүүлэхээр тохиролцож, төслийн нээлтийн семинарыг 2019 оны 4 дүгээр сарын 30-нд зохион байгуулсан. Төслийн хүрээнд пестицидийн үлдэгдлийг хянах төлөвлөгөөний төслийг боловсруулж, цахим хэлэлцүүлгийг 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулсан. Ковид-19 халдварт цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан тус төслийн хэрэгжих хугацааг 2021 оны 9 дүгээр сар хүртэл сунгасан. Төслийн хүрээнд импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хорио цээр, чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулах бодлогын арга хэмжээний санал боловсруулна. Азийн хөгжлийн банкны шугамаар хэрэгжүүлж байгаа “SPS-ийн арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд Замын –	30%

				Үүд, Сүхбаатар, Алтанбулаг хилийн боомтуудын хяналт, шалгалтын цогцолборыг барьж байгуулах зураг төслийг 2019 онд боловсруулж батлуулсан. Өргөтгөлийн ажлыг 2020 онд эхлүүлсэн байна.	
31	3.12. Хүнсний зориулалтын тээврийн хэрэгсэл болон агуулахын тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцлөөр импортлох санхүүгийн механизмыг бүрдүүлэх	2019 - 2023	0	Хүнсний зориулалтын тээврийн хэрэгслийг хөнгөлөлттэй нөхцлөөр импортлох санхүүгийн механизмыг бүрдүүлэх зорилгоор Хөгжлийн банкны дэргэд байгуулагдсан “ДиБиЭМ” ХХК-ийн холбогдох албан тушаалтнуудтай уулзаж санал солилцсон. Хүнсний зориулалтын тээврийн хэрэгслийн хэрэгцээ, шаардлагын талаарх судалгааг ирүүлэх албан тоотыг Монголын хүнсчдийн холбоонд хүргүүлсэн. Хүнсний зориулалтын тээврийн хэрэгслийг санхүүгийн хөнгөлөлттэй нөхцөл бүхий лизингээр нийлүүлэх гурван талт механизмыг бүрдүүлэхээр ажилласан. Гэвч Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 155 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны дэргэдх ДиБиЭМ лизинг ХХК-ийг татан буулгасан. Иймд дээрх механизмыг бүрдүүлэх өөр арга хэмжээний талаар судалж байна.	30%
32	3.13. Хүнсний худалдааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	2019 - 2023	0	Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг гаргаж, үнэлгээ, тайлбарын хамт ҮАБЗ-ийн ажлын албанд хүргүүлэв. Хүнсний аюулгүй байдлын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд ҮАБЗ-ийн ажлын хэсэгт хамтран ажиллаж байна. Хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалсан. Хүнсний аюулгүй байдлыг хангах салбар дундын уялдааг сайжруулах, тогтолцоог оновчтой болгох зорилгоор Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийг ажлын албатай болгох үндэслэл, шаардлага, арга хэмжээний саналыг боловсруулсан.	70%
33	3.14. Мал төхөөрөх үйлдвэрлэл эрхлэх асуудлыг аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрлөөр зохицуулах асуудлыг судлах	2019 - 2023	0	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, мал, мах бэлтгэн нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх, малын дайвар бүтээгдэхүүний ашиглалтыг сайжруулах зорилгоор мал төхөөрөх үйлдвэрлэл эрхлэх асуудлыг аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөр зохицуулах үндэслэл, тайлбар, саналыг боловсруулж, Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2020 оны 4 дүгээр сард хүргүүлсэн.	100%
34	3.15. Хоол, хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн шалтгааныг нарийвчлан тогтоож бүртгэх, эмнэлэгт хандаагүй тохиолдлыг тандан судлах, хариу арга	2019 - 2023	0	ЭМЯ-тай хамтран хоол, хүнсээр дамжих өвчний дэгдэлтийн шалтгааныг нарийвчлан тогтоож бүртгэх, эмнэлэгт хандаагүй тохиолдлыг тандан судлах, хариу арга хэмжээ авах шуурхай удирдлагыг хэрэгжүүлэх журмын төслийг шинэчлэн боловсруулах хэлэлцүүлэгт оролцон санал мэдээллийг солилцож ажилласан. Хоол хүнсээр дамжих өвчнөөс сэргийлэх зорилгоор хоол үйлдвэрлэгчдэд зориулсан хүнсний аюулгүй байдлын сургалтыг нийслэл, орон нутагт 6 удаа нийт 1000 гаруй хүнийг оролцуулан зохион байгуулж, мэдээлэл хүргэж ажилласан. Эрүүл ахуйн зохистой дадал хэвшүүлэх нь хоол хүнсээр дамжих өвчнөөс сэргийлэх хамгийн үр дүнтэй алхам тул хоолны газарт мөрдөхөөр шинэчлэн батлуулсан стандартад ЭАЗД-ыг заавал хэвшүүлсэн байх, аяга таваг халбага мэрээ угаах, ариутгах төхөөрөмжийг заавал суурилуулсан байх, хоолны	30%

	хэмжээ авах шуурхай удирдлагыг хэрэгжүүлэх			газрын ажилтны хувийн ариун цэвэр, ундын усанд тавих шаардлагуудыг нарийвчлан тусган батлуулсан. Энэхүү стандартыг хоолны газрууд мөрдөн ажиллаж байна. Дэлхийн хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын өдрийг тэмдэглэх уламжлалт хэвлэлийн бага хурлыг 2020 оны 6 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж, тус бага хуралд ЭМЯ-ны төлөөллийг оролцуулж, хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт, тандалтын талаар олон нийтэд мэдээлэл өгсөн.	
35	3.16. Хүнсний аюулгүй байдлын талаарх хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн цуврал нэвтрүүлгийг Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран бэлтгэж тогтмол хүргэх	2019 - 2023	0	Хөгжлийн бодлого, зохицуулалтын газар "Хүнсний аюулгүй байдлын цаг" цуврал нэвтрүүлгийн агуулга, зорилго, хуваарийг бэлтгэж МҮОНРТ-д хүргүүлсэн. Редакцийн цаг хүлээгдэж байна. Мөн 2020 онд Хүнсний аж үйлдвэрийн 90 жилийн ой болохтой холбогдуулан "Хүнс төрсөн түүх" нэвтрүүлгийг хамтран бэлтгэх саналыг бэлтгэж МХХ-нд хүргүүлэв. Энэ нэвтрүүлгийг хамтран бэлтгэх талаар ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А/188 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөнд тусгуулсан. "Мах сүүний анхдугаар аян"-ыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, цахим мэдээллийн сувгаар түгээх ажлыг зохион байгуулав. Үүнд: МҮОНТ-ийн "Олон нийтийн цаг шууд нэвтрүүлэг, Мах сүүний аяны танилцуулга 5 минутын бичлэг, сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор 1 минутын анимэйшин хийсэн. "МҮОНТ" ТВ-1удаа; а. "Хүн ба хүнс" сэтгүүл-1 удаа; b. Parliamentnews.mn, newtoim.mn shuudmedee.mn, pressnews.mn, newmedia.mn зэрэг сайтад 10 удаа с. ХХААХҮЯ-ны сайт-17 удаа+нөөцийн махны явц, борлуулалтын мэдээ, махны экспорт, мах сүүний аяны явцын мэдээ өгсөн. Хүнсний аюулгүй байдлын талаарх хэрэглэгчийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор 2020 оны 3 дугаар сард ТВ-5 телевизийн "Ээжүүд-Эрүүл ирээдүйн төлөө" нэвтрүүлэгт оролцож, олон нийтэд зөвлөгөө, мэдээлэл өгөв. Мөн хүнсний хангамж, нөөцийн асуудлаар Монгол ТВ-ийн Хар хайрцаг нэвтрүүлэгт 2020 оны 5 дугаар сард оролцож, олон нийтэд мэдээлэл өгөв. Улсын хэмжээнд зохион байгуулсан "Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье" аяны хүрээнд олон нийтийн хүнсний талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Ийгл ТВ-ийн зорилтот нэвтрүүлэгт оролцож, мэдээлэл өгөв.	100%
36	3.17. Хүнсний хаягдал, хорогдлын судалгааг хийж, түүнийг бууруулах, дахин ашиглах арга замыг тодорхойлж, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд сурталчлан таниулах	2019 - 2023	0	Сүүний үйлдвэрлэлийн технологийн шат дамжлага дахь хорогдлын нормыг тогтоох судалгааны ажлыг "Хоршоологчдын ертөнц" ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлж, судалгааны тайланг 2019 оны 12 дугаар сард хүлээн авсан. Хорогдлын нормыг тогтоох арга хэмжээний саналыг боловсруулж байна	30%

4. Хүнсний боловсруулах салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлш, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ						
37	4.1. Худалдааны түнш орон, бүс нутагтай байгуулах Чөлөөт худалдааны хэлэлцээрт тухайн зах зээлд хүнсний бүтээгдэхүүн экспортлох тарифын хөнгөлөлттэй нөхцлийг тусгах	2019 - 2023	0		Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Өргөн хэрэглээний бараа болох гурил, элсэн чихэр, будаа, малын тэжээл, хивэг, өвсийг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганы 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хүнсний бүх төрлийн будаа, ургамлын тос, малын гаралтай өвс тэжээлийг Гааль болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцэхийг олонхийн саналаар дэмжиж, анхны хэлэлцүүлэгт шилжүүлж, УИХ-ийн хуралдаанаар батлуулсан.	100%
38	4.2. Худалдааны түнш орнуудтай байгуулсан мал эмнэлэг, ургамал, хорио цээрийн хэлэлцээрийг хянан үзэх, шинэчлэх, шинээр байгуулах	2019 - 2023	0		1. "БНХАУ руу экспортлох хөх тариа, улаан буудайн гурилын ургамлын хорио цээрийн шаардлагын тухай Протокол"-ыг эцэслэн байгуулж Хятад руу гурил экспортлох эрх зүйн үндсийг төгөлдөржүүлэв. 2. "БНСУ руу экспортлох ариутгасан махан бүтээгдэхүүний эрүүл ахуйн Гэрчилгээ"-ний загварыг эцэслэн тохирч Солонгос руу ариутгасан махан бүтээгдэхүүн экспортлох эрх зүйн үндсийг бий болгов. 3. Аргентин Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яамтай "Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичиг"-ийг байгуулж, "Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах Протокол"-ыг эцэслэн тохиролцох яриа, хэлэлцээ хийж байна. 4. БНХАУ руу экспортлох зөгийн бал, сүү, сүүн бүтээгдэхүүн, малын дайвар түүхий эдийн экспортын эрх зүйн орчныг бий болгох, холбогдох Протоколыг байгуулах яриа, хэлэлцээ хийж байна. Эдгээр бүтээгдэхүүний мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын асуумжийн хариуг боловсруулан хүргүүлээд байна. 5. АНУ-тай "Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Протокол болон Санамж бичиг"-ийг байгуулахаар Америкийн талтай яриа, хэлэлцээ хийж байна. 6. ИБНИУ-тай "Мал, амьтны эрүүл мэнд болон мал эмнэлгийн үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах тухай Хэлэлцээр" байгуулахаар Ираны талтай яриа, хэлэлцээ хийж байна. 7. БНАЗерУ-тай "Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Сангамж бичиг"-ийг байгуулахаар Азербайжаны талтай яриа, хэлэлцээ хийж байна. 8. БНСВУ руу экспортлох гүн хөлдөөсөн махны экспортын эрх зүйн орчныг бий болгох яриа, хэлэлцээ хийж 2020 онд нийт 5 удаа хяналтын асуумжийн хариуг боловсруулан хүргүүлэв. 9. Япон Улсын ХААЯ-наас ирүүлсэн мах, махан, сүү, сүүн бүтээгдэхүүний мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын асуумжийн хариуг боловсруулан хүргүүлэв. *** Өмнө нь байгуулсан хорио цээрийн Протокол болон холбогдох баримт, бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
39	4.3. Хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны	2019 - 2023	0		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар Сайдын нэрэмжит грант горилж дэвшсэн бүтээлүүдийг хэлэлцэн,	30%

	ажлын үр дүн, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх			<p>батламжиллаа. Сайдын нэрэмжит грантын шалгаруулалтыг ХХААХҮ-ийн Сайдын 2017 оны А-36 дугаар тушаалаар баталсан “Салбарын судалгаа, хөгжлийн ажилд грант олгох журам”-ын дагуу зохион байгууллаа. Сайдын нэрэмжит грант горилж ирүүлсэн мал аж ахуй, мал эмнэлэг, газар тариалан, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн эдийн засаг, техникийн чиглэлийн бүтээлүүдийг шинжлэх ухааны багтаамж буюу технологийн түвшин, техник эдийн засгийн үзүүлэлт, зах зээлийн эргэлтэд орох чадамжийн түвшин буюу үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ашиглах бодит боломж, ижил төстэй технологи, бүтээгдэхүүн үйлчилгээнээс давуу тал, өрсөлдөх чадвар, нэмүү өртөг бий болгож буй түвшин зэрэг шалгуур үзүүлэлтийг хангасан байдлаар нь үнэлгээ өгөн шалгаруулсан байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын “Судалгааны ажилд инновацийн грант олгох тухай” 2020 оны А-231 дүгээр тушаалаар дараах 5 бүтээлийн багт Сайдын нэрэмжит грантыг олгосон. Энэхүү 5 бүтээлд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хүнс, судлалын эрдэм шинжилгээний төвийн эрхлэгч, доктор (Ph.D), Г.Төрмөнх удирдагчтай “Хүнсний бүтээгдэхүүнийг бичил шим гэжээл био-иодоор баяжуулах судалгаа-үйлдвэрлэлийн дүн” сэдэвт бүтээл шалгарсан байна.</p>	
40	4.4. Экспортын баримжаатай хүнсний боловсруулах салбарт технологийн шинэчлэл хийх, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалтын сан байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих	2019 - 2023	0	<p>Хүнсний салбарт хөрөнгө оруулах хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах боломж, арга замын талаар судалж байна. Хүнсний салбарт санхүүгийн эрэлт, хэрэгцээ шаардлага өндөр байна. Тухайлбал, Хөрөнгийн зах зээлд "Сүү" ХК "Сүү бонд" гаргасан, "Түмэн шувуут" ХХК болон "Монос хүнс" ХХК IPO гаргасан зэргийг дурдаж болно. Хүнсний салбарт гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах боломж, санхүүжүүлэх арга замыг тодорхойлох зөвлөлдөх уулзалтыг 2020 онд зохион байгуулахаар хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж байна. Уул уурхайн орлогоос хувийн хэвшилд хуримтлагдсан хөрөнгөөс Хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулах нь чухал байна. Хүнсний салбар нь зах зээлд бүтээгдэхүүний эргэлт хурдан байдаг онцлогтой. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, холбогдох төсөл хөтөлбөрүүдтэй хамтран чацаргана жимс үйлдвэрлэл, чацарганы чанамал, шүүс, хуурайшуулсан бэлдмэл, тос зэрэг бренд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх талаар ажиллаж, экспортлох нөхцөл, боломжийг бүрдүүлэв. Тухайлбал, “Хаан жимс Эс Би Ти” ХХК-ийн “Хуба Хаяа” үйлдвэр нь Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO22000 стандартыг нэвтрүүлсэн бөгөөд тус компани нь бүтээгдэхүүнээ Тайван, Япон, Хятад, Солонгос, Герман зэрэг улсуудад бүтээгдэхүүнээ экспортолж байна. Азийн хөгжлийн банкнаас хөдөө аж ахуйн гаралтай худалдан авалтын дэд бүтцийг дэмжих, экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд технологийн шинэчлэл хийхэд нь зориулж ТЭСО корпорацийн Милко компанитай санхүүжилтийн гэрээг байгуулав. Энэ арга хэмжээ нь Азийн хөгжлийн банкнаас манай улсын хувийн хэвшилд анх удаа төгрөгийн зээлийг шууд олгосноороо онцлогтой. Экспортын баримжаатай хүнсний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх,</p>	30%

				санхүүжилтыг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн банк байгуулах үндэслэл, шаардлага, арга хэмжээний талаар санал боловсруулж, яамны удирдлагуудад танилцуулсан.	
41	4.5. Экспортлох боломжтой хүнсний нэр, төрлийг тодорхойлох, үйлдвэрлэлийг нь Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар тэргүүн ээлжинд дэмжих механизмыг бүрдүүлэх	2019 - 2023	0	Жижиг дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт, чиглэлийг Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 190 дүгээр тогтоолоор баталсан. Тэргүүлэх салбарын жагсаалтад сүү, сүүн бүтээгдэхүүн, мах дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэл, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэрлэл, харин тэргүүлэх чиглэлд хүнсний баяжуулах болон органик үйлдвэрлэлийг багтаасан болно. Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор "ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих" журмыг шинэчлэн баталсантай холбогдуулан ЖДҮ-ийн хүрээнд тэргүүн ээлжинд дэмжих салбар, чиглэлийн жагсаалтад хүнсний тэргүүлэх салбар, дараах чиглэлийг оруулах саналыг хүргүүлж тусгуулсан. Үүнд: сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сав баглаа боодлын үйлдвэрлэл, дайвар бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэл, органик хүнсний үйлдвэрлэл.	100%
42	4.6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах дотоодын хүнсний нэр, төрлийг нэмэгдүүлэх	2019 - 2023	0	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах дотоодын үйлдвэрийн 14 бүлгийн 155 нэр төрлийн бүтээгдэхүүний жагсаалтыг боловсруулж Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор шинэчлэн батлуулж, дотоодын үйлдвэрүүд бүтээгдэхүүнээ төсвийн байгууллагын худалдан авалтад хамруулах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн. 2. Засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоолоор 2019 ОНЫГ “ЭХ ОРОНЧ ХУДАЛДАН АВАЛТЫН ЖИЛ” болгон зарлаж, тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад, дотоодод үйлдвэрлэсэн үндэсний бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэхийг нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд уриалахыг үүрэг болгосон. Эдгээр бараа, бүтээгдэхүүний жагсаалтад хүнсний бүтээгдэхүүний бүлэгт шинэ буюу хөлдөөсөн, хатаасан төмс, хүнсний ногоо гэж нэмж оруулсан. Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолын хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний талаарх тайланг улсын хэмжээнд нэгтгэн дүгнэж, Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан.	100%
43	4.7. Монгол Улсын хүнсний экспортыг “өндөр үнээр, цөөн тоогоор” стратегийн хүрээнд хэрэгжүүлэх	2019 - 2023	0	Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журмыг шинэчилж Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор батлуулсан. Журамд хүнсний экспорт, импортын нэг цонхны бодлого хэрэгжүүлж болох зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, нэг цонхны бодлогыг барааны гэрчлэх тэмдэг эзэмшигч мэргэжлийн холбоо, гадаад худалдаа эрхлэгч хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн байгуулсан нэгдэл /консорциум/ эсхүл төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлж болно. Энэ бодлогын зохицуулалтын үр дүнд хүнсний экспортын үр ашгийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна. Энэ стратегийн	70%

				хүрээнд Гурил үйлдвэрлэгчдийн холбооны удирдлагатай 2020 оны 6 дугаар сарын 09-нд уулзаж, санал, мэдээлэл солилцсон. Дээрх журамд нэмэлт оруулж Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.	
44	4.8. Газар зүйн заалттай хүнсний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, экспортыг гадаад улс, олон улсын байгууллагын хөтөлбөр, төсөлд хамруулж дэмжих	2019 - 2023	0	Газар зүйн заалттай хүнсний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх техник туслалцааны төслийн баримт бичгийг боловсруулж, гадаад улс, олон улсын байгууллагын шугамаар төсөл, хөтөлбөрт хамруулахаар ГХАХ-т 2020 оны 3 дугаар сард хүргүүлсэн. Хүнсний тусламжийн хамтын ажиллагааны хүрээнд Франц Улсаас Монгол Улсад газар зүйн заалттай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төсөл хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Увс аймгийн чацарганыг газар зүйн заалт бүхий жишиг бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх, үйлдвэрлэлийн тогтолцоо, чацарганы бүтээгдэхүүний борлуулалт, удирдлагын үйл ажиллагаанд судалгаа хийж, санал зөвлөмж гаргасан. Увсын чацарганыг ЕХ-ны газар зүйн заалтад бүртгүүлэх, улмаар тус холбооны гишүүн орнуудын зах зээлд экспортлох чиглэлд МҮХАҮТ-аас ХБНГУ-ын ХАҮТ-тай хамтран Pro Value төслийг хэрэгжүүлж байна.	70%
45	4.9. Органик мал аж ахуй, газар тариалан, зөгийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх	2019 - 2023	0	Сэлэнгэ аймгийн 11 сумын 30 хөдөө аж ахуйн хоршоодын гишүүд- ногоочдыг органик хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хамтын баталгаажуулалтын зарчмын дагуу органик бүтээгдэхүүн /хүнсний ногоо, зөгийн бал, сүүн бүтээгдэхүүн/ үйлдвэрлэх, хамтран баталгаажуулах, зах зээлд борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Холбооны Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (санхүүжилтийн 75%) болон ADRA Герман олон улсын байгууллага (санхүүжилтийн 25%) хамтран 1 сая еврогийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Органик хөдөө аж ахуйн түншлэл” төслийг хэрэгжүүлж байна. “Органик хөдөө аж ахуйн түншлэл” төсөл 2019 онд “Сэлэнгэ органик” хамтын баталгаажуулалтын байгууллагын дор нийт 10 суманд анхан шатны 30 хоршоо, нэг дундын хоршоог сонгон авч органик хөдөө аж ахуй, органик хүнс үйлдвэрлэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хандлагыг өөрчлөх, чадавхжуулах олон төрлийн сургалт явуулж, тоног төхөөрөмж, санхүүгийн дэмжлэг үзүүлэн, иргэд, хоршоодын талбайгаас хөрс, усны дээж авах, шинжлүүлэх зэрэг олон ажлыг зохион байгуулж байна. Үүний үр дүнд 2020 оны 12 сарын байдлаар энэхүү төслийн дэмжлэгтэйгээр Органик хүнсний бүртгэл, мэдээллийн www.organic.gov.mn цахим санд бүртгэлтэй, эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар баталгаажсан дотоодын үйлдвэрийн 382 органик, шилжилтийн үеийн 238, импортын 25 органик хүнсийг зах зээлд нийлүүлсэн байна. АХБ-ын шугамаар “Органик хүнс” төслийг хэрэгжүүлэхээр 2020 оны 3 дугаар сард удирдлагын түвшинд хэлэлцэж, төслийн баримт бичгийг боловсруулж хүргүүлсэн.	100%
46	4.10. Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор ойн дагалт	2019 - 2023	0	“Аствишн” ХХК “Органик хүнсний бүртгэл, мэдээллийн системд техникийн үйлчилгээ үзүүлэх” 191113/08/478 дугаартай гэрээнд заасны дагуу баталгаажуулалтын үйл ажиллагааг тухайн аж ахуйн нэгжийн газрын байршлын өгөгдөлтэй уялдуулж гүйцэтгэх ажлыг эхлүүлсэн. Органик	100%

	баялаг болон байгалийн ургамал түүж, ашиглах талбайг тодорхойлох			хүнсний бүртгэл мэдээллийн сан www.organic.gov.mn -д баталгаажсан органик болон шилжилтийн үеийн хүнсийг бүртгүүлэх тохиолдолд үйлдвэрлэгчийн зүгээс органик үйлдвэрлэл явагдаж буй талбайн байршил, координатыг оруулж байна. Ингэснээр органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах боломжтой талбайн байршлын талаарх мэдээллийн сан бүрдүүлж байна.	
47	4.11. “Органик хүнс хөдөө аж ахуйн Үндэсний Зөвлөл”-ийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах, органик газар тариалан, мал аж ахуй эрхлэх бүсийг тогтоох талаар арга хэмжээний санал боловсруулах	2019 - 2023	0	“Аствишн” ХХК “Органик хүнсний бүртгэл, мэдээллийн системд техникийн үйлчилгээ үзүүлэх” 191113/08/478 дугаартай гэрээнд заасны дагуу баталгаажуулалтын үйл ажиллагааг тухайн аж ахуйн нэгжийн газрын байршлын өгөгдөлтэй уялдуулж гүйцэтгэх ажлыг эхлүүлсэн. Органик хүнсний бүртгэл мэдээллийн сан www.organic.gov.mn -д баталгаажсан органик болон шилжилтийн үеийн хүнсийг бүртгүүлэх тохиолдолд үйлдвэрлэгчийн зүгээс органик үйлдвэрлэл явагдаж буй талбайн байршил, координатыг оруулж байна. Ингэснээр органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах боломжтой талбайн байршлын талаарх мэдээллийн сан бүрдүүлж байна.	100%
48	4.12. “Органик бордоо үйлдвэрлэж сурцгаая” хөдөлгөөнийг сумын түвшинд өрнүүлэх	2019 - 2023	0	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын бүтээмжийн төв, Адра Монгол ОУБ, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Монгол ногоо төсөл, Азийн бүтээмжийн байгууллага, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, МҮХАҮТ-тай хамтран “Органик бордоо” сургалт, дадлагыг 2 жил дарааллан зохин байгуулсан бөгөөд Төв аймгийн Баянчандмань суманд үйл ажиллагаагаа явуулдаг “Монгол экологийн бордоо” ХХК-ийн био бордооны үйлдвэр, ХХААХҮЯ дээр практик дадлага хийсэн. Сургалтыг Азийн бүтээмжийн байгууллагын зөвлөх Камал Мелвани 2018-2019 онд 2 жил дарааллан удирдан явуулсан бөгөөд өөрийн 25 жилийн мэдлэг, туршлагаа Монголын газар тариалан эрхлэгчид, хөдөө аж ахуйн малчид, фермерүүдэд хуваалцан, хөрсний чанарыг сайжруулах арга зам, шинэ технологи ашиглаж болох талаар мэдлэг, дадлагыг сургалтад оролцогчдод эзэмшүүлсэн. Практик дадлагын үеэр үхрийн шээсээр jeevamurtham буюу шингэн органикт бордоо, сармис, тараг, савангийн уусмалаар био пестицид, фунгицид бэлтгэх талаар маш дэлгэрэнгүй нэг бүрчлэн зааж, хивэг, жимс, ногооны хаягдал, нунтаг чулуу, ойн хөрс, модны үнс, ус, аргал, үхрийн шээс зэрэг хямд төсөр, олдоц ихтэй түүхий эд ашиглан органик бордоо үйлдвэрлэж болохыг бодитоор харуулав. Энэхүү хичээлийг видео хичээл болгож, Сэлэнгэ аймгийн 150 гаруй ногоочдод тараасан болно. Органик бордооны дараах стандартыг 2020 онд баталсан байна. Үүнд: 1. Органик хуурай бордоонд нийт азот тодорхойлох арга. 2. Органик хуурай бордоо. Органик бодис тодорхойлох Оксидиметрийн арга. 3. Органик хуурай бордоонд нийт фосфор тодорхойлох арга. 4. Органик хуурай бордоонд нийт кали	100%

				тодорхойлох арга. 5. Органик бордоонд аммоны азот тодорхойлох арга. 6. Органик бордоонд орчин/РН/ тодорхойлох арга.	
49	4.13. Органик хүнс, хөдөө аж ахуйг дэмжих зорилгоор олон улсын арга хэмжээ зохион байгуулах	2019 - 2023	0	“Алсыг харъя, Органикийг сонгоё” уриан дор "Азид Органик ХАА-н манлайллыг төлөвшүүлэх нь" олон улсын сургалтыг 2020 оны 11 сарын 4-6-ны өдрүүдэд Zoom дижитал платформ ашиглан зохион байгуулсан. Хурлын үйл ажиллагаанд Ази номхон далайн 10 улсын 19 оролцогч, Монголоос 28 төлөөлөгч, IFOAM-Organics International олон улсын байгууллагын дэргэдэх Органик Академийн захирал Конрад, IFOAM Asia олон улсын байгууллагын Гүйцэтгэх захирал Женнифер Чанг, Азийн бүтээмжийн төвийн Тсөлө хариуцсан захирал гэх мэт нөлөө бүхий албан тушаалтнууд оролцсон. Тус газраас Монгол улсын Органик хөдөө аж ахуйн хөгжлийн чиглэлээр 30 минутын презентацийг тавьж, хэлэлцүүлсэн бөгөөд салбар хуралдааны үеэр В хэсгийг төлөөлж, мэдээлэл хийсэн. Органик хүнсний бүртгэл мэдээллийн сангийн системийг олон улсад жишиг болохуйц санаачилга байна гэж хурлын даргалагч болон оролцогчдоос өндөр үнэлсэн.	100%
5. Хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ					
50	5.1. Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх, санал боловсруулах	2019 - 2023	0	Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг гаргаж, үнэлгээ, тайлбарын хамт ҮАБЗ-ийн ажлын албанд хүргүүлэв. Хүнсний аюулгүй байдлын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд ҮАБЗ-ийн ажлын хэсэгт хамтран ажиллаж байна. Хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалсан. Хүнсний аюулгүй байдлыг хангах салбар дундын уялдааг сайжруулах, тогтолцоог оновчтой болгох зорилгоор Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийг ажлын албатай болгох үндэслэл, шаардлага, арга хэмжээний саналыг боловсруулсан.	70%
51	5.2. Хүнсний салбарт инноваци, шинэ технологи нутагшуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх үүрэгтэй Судалгаа хөгжлийн төвийг байгуулах асуудлыг судлах	2019 - 2023	-	Хүнсний салбарт инноваци, шинэ технологи нутагшуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх үүрэгтэй Судалгаа хөгжлийн төвийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын хэлбэрээр зохион байгуулахаар судалж байна. ХХААХҮ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаардаг харьяа дараах 3 байгууллагыг нэгтгэж, Судалгаа хөгжлийн төв байгуулах бодлогын асуудалд санал боловсруулж 2020 оны 5 дугаар сарын 29-нд хүргүүлэв. Үүнд: 1. “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв”, төрийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар, 2. “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, 3. “Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүс” улсын төсөвт байгууллага. ХХААХҮ-ийн салбарын судалгаа хөгжлийн төвийг Засгийн газрын 2020 оны 93 дугаар тогтоолоор байгуулсан.	100%

52	5.3. Хүнсний аюулгүй байдлын бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх	2019 - 2023	-	Стратегийн болон гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний тэнцлийг тооцоолох программ боловсруулах ажлыг 2019 онд хийж гүйцэтгэсэн, программыг байршуулах серверийн асуудал шийдвэрлэсний дараа ашиглах нөхцөл, боломж бүрдэнэ. Хүнсний аюулгүй байдлын бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх төслийн баримт бичгийг боловсруулж, “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх уулзалтын үеэр гадаад улс, олон улсын байгууллагуудад танилцуулсан. Мөн 2020 оны төсөвт санал хүргүүлсэн. Гэвч СЯ-нд хасагдсан.	50%
53	5.4. Хүнсний сорилт, чанар, аюулгүй байдлын итгэмжлэгдсэн лабораториудын мэдээллийн сүлжээг зохион байгуулах	2019 - 2023	-	Хүнсний сорилт, чанар, аюулгүй байдлын итгэмжлэгдсэн лабораторийн мэдээллийн сүлжээг зохион байгуулахаар судалж байна. Төрийн холбогдох чиг үүрэг хэрэгжүүлдэг лабораториуд болон хувийн хэвшлийн лабораториуд хооронд мэдээлэл, шинжилгээний үр дүнгээ харилцан солилцдог байх зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай байна. Иймд Монгол Улсын хүнсний чиглэлийн лабораториудын зөвлөлдөх ажлын уулзалтыг 2020 оны 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байсан боловч Ковид-19 халдварт цар тахлын нөхцөл байдлын улмаас цуцлагдсан.	30%
54	5.5. Хүнсний салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, хүнсний сүлжээнд зохистой дадлын сургалт зохион байгуулах зэрэг төрийн чиг үүргийг салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, их, дээд сургуульд шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх	2019 - 2023	-	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д заасан “.. зохистой дадлын сургалт зохион байгуулах” чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоогоор гүйцэтгүүлэх санал боловсруулав. Мөн НҮБ-ын ХХААБ болон ДЭМБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Хүнсний хяналтын тогтолцоог сайжруулах” техник туслалцааны төслийн хүрээнд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж хүргүүлэв. Хүнсний салбарын мэргэжилтэн мэргэшлийн зэрэг олгох, мэргэжил дээшлүүлэх, хүний нөөцийн тогтолцоог сайжруулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, УИХ-д хэлэлцүүлэхээр 2020 оны 5 дугаар сард өргөн барьсан.	70%
55	5.6. “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт”-ыг хүнсний салбарын мэргэжлийн онцлогтой уялдуулж шинэчлэх	2019 - 2023	-	Монгол Улс хүнс экспортлогч орон болох стратегийн зорилтын хүрээнд хүнсний салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хүний нөөцийн чадавхийг сайжруулах нь чухал ач холбогдолтой. Иймд хүнсний салбарт мэргэжилтэн бэлтгэдэг төрийн болон хувийн хэвшлийн 11 сургуулийг хамруулсан хамтын ажиллагааны механизм бүрдүүлэх зорилгоор зөвлөлдөх уулзалтыг 2020 оны 1 дүгээр сард ХХААХҮЯ-нд зохион байгуулсан. “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолт”, "Мэргэжлийн индекс"-ийг хүнсний үйлдвэр, худалдаа, хоол үйлдвэрлэлийн салбарт шинэчлэх чиглэлээр мэргэжлийн холбоод, ажил олгогчдын саналыг авч ХНХЯ-нд хүргүүлсэн.	100%

56	5.7. Хүнсний салбарт эрэлт өндөртэй мэргэжлийг Монгол Улсын тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлд хамруулах	2019 - 2023	-	Хүнсний инженерчлэл мэргэжлийг Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалтад багтаасан.	100%
57	5.8. Хүнсний чиглэлээр суралцаж байгаа тэргүүний оюутнуудад хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний нэрэмжит тэтгэлэг олгох асуудлыг судалж шийдвэрлүүлэх	2019 - 2023	-	"Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөрийн 3.5.7-д заасны дагуу хүнсний инженерчлэл мэргэжлийн чиглэл Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалтад багтсан. Энэ зохицуулалтаар оюутнууд сургалтын төрийн сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах нөхцөл бүрдсэн. Жил бүрийн 10 дугаар сард "Дэлхийн хүнсний өдөр"-ийг тохиолдуулан "Хүнсний аюулгүй байдал-" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, шалгарсан 3-4 оюутанд мөнгөн шагнал олгож байна.	50%
58	5.9. Монгол Улс хүнс экспортлогч гүрэн болох стратегийн хүрээнд хүнсний салбарын мэргэжил сурталчлах өдөрлөгийг жил бүр зохион байгуулж хэвших	2019 - 2023	-	Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хувьд санаачлан төр, хувийн хэвшлийн холбогдох их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны механизм бий болгох санаачилгыг дэвшүүлж, тус ажлыг хэрэгжүүлэх боломж, арга замын талаарх зөвлөлдөх уулзалтыг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр ХХААХҮЯ-ны хурлын танхимд зохион байгуулав. Тус уулзалтад МУИС, ШУТИС, ХААИС, АШУҮИС, Идэр их сургууль, Техник технологийн дээд сургууль, Технологийн дээд сургууль, Эм зүйн шинжлэх ухааны их сургуулийн төлөөлөл 20 гаруй хүн оролцов. Монгол Улсын хүнсний аж үйлдвэрийн салбарын 90 жилийн ой 2020 онд тохиож байгаатай холбогдуулан дээрх бүтээлч санаачилгыг ажил хэрэг болгох, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, судалгаанд суурилсан бодлого хэрэгжүүлэх, их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны уялдааг хангах, дотоодын хүнсний үйлдвэрүүдийн захиалга, эрэлт хэрэгцээнд тулгуурлан мэргэжилтэн сургаж бэлтгэх, эрдэм шинжилгээ, судалгаа – үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэхийн чухлыг оролцогчид онцолж байв. Зөвлөлдөх уулзалтын мөрөөр авах арга хэмжээний санал болгон "Монгол хүнсчин" нийгэмлэгийг байгуулах үндэслэл, шаардлага, мөн нийгэмлэгийн дүрмийн төслийг боловсруулсан. "Монгол хүнсчин" нийгэмлэгийг манлайлан зохион байгуулах асуудлаар ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль, Технологийн дээд сургуулийн удирдлагуудтай уулзаж, санал хүргүүлсэн. Хүнсний аж үйлдвэрийн 90 жилийн ойн хүрээнд салбарын мэргэжил сурталчлах өдөрлөгийг 2020 оны 11 дүгээр сард зохион байгуулах байсан боловч Ковид-19 халдварт цар тахлын нөхцөл байдлын улмаас хойшлуулсан.	30%

59	5.10. Хүнсний боловсруулах салбарын нарийн мэргэжлийн ажилтныг гадаад улсын ахисан шатны сургалтад тогтмол хамруулах механизмыг бүрдүүлэх	2019 - 2023	-		Хүнсний салбарт хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх стратегийн хүрээнд Хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн нийгэмлэгтэй хамтран Сингапур улсын Нанянг политехник олон улсын байгууллагын удирдлага, холбогдох ажилтнуудтай 2020 оны 9, 11-р сард тус бүр цахим уулзалт зохион байгуулж, тус улсын Темасек байгууллагын шугамаар манай улсад хэрэгжүүлэх техник туслалцааны төслийн саналын талаар санал, мэдээлэл солилцсон. Энэ ажлын хүрээнд Сингапур улсын Темасек хөрөнгө оруулалтын байгууллагад албан хүсэлтийг 2020 оны 11 дүгээр сарын 05-нд хүргүүлсэн. Төслийн үйл ажиллагаа 2021 онд эхлэх бөгөөд нийт 150 гаруй хүн сургана.	30%
						70.85%